



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 25

Хэрлэн сум

Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын мэргэжилтний
сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6, 5.7, 3.5, 3.5.4, 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7.2, 7.3, 7.4, 7.7-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /87/ авсан Цогтгэрэлийн Эсүжинг Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Ц.Эсүжинг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг ажлын 14 өдрийн дотор албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга /З.Ууганжаргал/-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын даргад хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Эрдэнэжаргал/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР